УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2017 оны 08 сарын 11 өдөр Дугаар А/129 Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
нэрэмжит үзлэг зохион байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар албан даалгавар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хэрхэн хангагдсан талаар хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган, шаардлагатай арга хэмжээ авах зорилго бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн "Нэрэмжит үзлэг" зохион байгуулах Ажлын хэсгүүдийг 1 дүгээр хавсралтаар, удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Нэрэмжит үзлэг"-ийг зохион байгуулж, дүнг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгүүд /Т.Хэрлэн, Г.Ууганбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2017\tushaal 2017.docx

1110300613

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017 оны 08 сарын 11-ний өдрийн
А/128 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН НЭРЭМЖИТ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

1. Инженерийн хангамжийн байгууллагуудад үзлэг, шалгалт хийх ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Э.Хишигбуян	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Х.Наранбаатар	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Б.Түвшинжаргал	Шуурхай удирдлага, зохицуулалтын төвийн диспетчер инженер
Нарийн бичгийн дарга	Д.Оюунжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн

2. Дүүрэг, тохижилтын чиглэлээр үзлэг, шалгалт хийх ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

	Т.Туул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	З.Мөнгөнзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017 оны 08 сарын 11-ний өдрийн .....
А/129 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
НЭРЭМЖИТ ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ

Нэг. Үзлэгийн зорилго

Улаанбаатар хотын хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангагдсан талаар хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган, шаардлагатай арга хэмжээ авах зорилго бүхий дүүрэг болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харъяа байгууллага, инженерийн хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Нийслэлийн төвийн 6 дүүрэг, ДЦС-4 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-2 ТӨХК, ЦДҮС ТӨХК-ний Улаанбаатар салбар, УБЦТС ТӨХК, УБДС ТӨХК, Амгалан дулааны станц, Нийслэлийн Тээврийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Ус сувгийн удирдах газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, Сууц өмчлөгчдийн холбоод хамрагдана.

Гурав. Үзлэг, шалгалтын чиглэл

Дулааны цахилгааны станцууд, Амгалан дулааны станц

1. Нүүрсний нөөц
2. Үндсэн цехүүдийн шуурхай ажиллагааны схем
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, багаж хэрэгсэл, галын аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний Улаанбаатар салбар

1. Шинээр ашиглалтанд орсон дэд станцуудын шуурхай ажиллагааны схем
2. Салбарын хэмжээнд аваарийн нөөц бүрдүүлэлт, бэлэн байдал
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, багаж хэрэгсэл, галын аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК

1. Түгээх төвүүдийн аваарийн нөөц /0,4кВ, 10кВ, 35кВ-ын кабель шугам, муфьт, таслуур/
2. Урсгал засварын явцын мэдээлэл
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, багаж хэрэгсэл, галын аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК

1. Төв шугамын тохируулгын цэгүүдийн горим ажиллагааны байдал
2. Урсгал засварын явцын мэдээлэл
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, багаж хэрэгсэл, галын аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар

1. Өөрийн хөрөнгөөр хийгдэж байгаа их болон урсгал засварын ажлыг халаалтын улирлаас өмнө гүйцэтгэж дуусгасан байдал,
2. Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, хяналт хийх зориулалттай нээлхий, худаг камерын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эвдрэх, үрэгдэх тохиолдол бүрт шуурхай сэргээн, аюулгүй байдлыг хангасан, аваарийн нөөц бүрдүүлсэн байдал,
3. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд онцгой анхаарах ажлууд:

- Аваарийн нөөцөнд 35квт-с дээш ачаалал даах чадвартай цахилгааны тэжээлийн уян кабель бэлтгэсэн байдал,
- Халаалт, халуун ус, хүйтэн ус, бохирын шугам, ус, дулаан дамжуулах төвүүдэд нөөц насос, автомат удирдлагын самбар болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг нөөцөнд бэлтгэсэн байдал,

4. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай бусад аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах талаар хийсэн ажил.

Ус сувгийн удирдах газар

1. Усан хангамжийн эх үүсвэр, өргөлтийн насос станц, цэвэрлэх байгууламжуудын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан байдал,
2. Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, хяналт хийх зориулалттай нээлхий, худаг камерын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эвдрэх, үрэгдэх тохиолдол бүрт шуурхай сэргээн, аюулгүй байдлыг хангасан байдал,
3. Төв, Урьдчилан цэвэрлэх, Баянголын ам, Нисэх зэрэг цэвэрлэх байгууламжуудын хэвийн найдвартай ажиллагааг хангасан байдал,
4. Цэвэрлэх байгууламжуудын тунгаагуур, аэротенкийн их, урсгал засварыг графикт хугацааны дагуу гүйцэтгэсэн байдал,
5. Бохир усны дамжуулах Туул-1, 24, Налайх 3үүн Сэлбэ коллекторуудын ашиглалт үйлчилгээг хариуцан ажилласан байдал.

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар

1. Их болон урсгал засварын ажлыг халаалтын улирлаас өмнө гүйцэтгэсэн байдал,
2. Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, хяналт хийх зориулалттай нээлхий, худаг камерын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эвдрэх, үрэгдэх тохиолдол бүрт шуурхай сэргээн, аюулгүй байдлыг тогтмол хангаж ажилласан байдал,
3. Харьяа зуухнуудын нүүрсний нөөцийг халаалтын улирлаас өмнө татах ажлыг зохион байгуулсан байдал,
4. Аваарын нөөцөнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрдүүлсэн байдал.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

1. Авто зам, явган зам, талбайн халтиргаа гулгаанаас сэргийлж, шаардагдах элс давс, тусгай зориулалтын бодисыг хангалттай нөөцлөх арга хэмжээ авсан байдал,
2. Зам талбайн цэвэрлэгээ, арчилгаа тогтмолжсон байдал,
3. 2016-2017 оны өвөлжилтийн хугацаанд хүмүүсийн халтирч унаж гэмтсэн байршлын судалгааг гарган тус байршлуудыг халтиргаанаас хамгаалж зам талбайг тэгшлэх, хотгор гүдгэрийг зассан байдал,
4. Ажилчдын өвлийн хувийн бэлтгэлийг хангуулан, өвлийн нормын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангасан байдал,
5. Нарангийн энгэр, Морин даваа, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа, автопүүний хяналт, тогтвортой ажиллагааг шалгах,
6. Машин механизмын засвар, техникийн үйлчилгээг бүрэн хийсэн байдал, бүртгэлжүүлэлт,
7. Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдал,
8. Шинэлэг санаа, санаачлагыг нэвтрүүлэн ажилласан байдал.

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд

1. Сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн засвар шинэчлэлтийн ажлуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран байнгын ашиглалтанд оруулсан байдал,
2. Гэрэл дохионы найдвартай ажиллагааг хангах, хүйтэн сэрүүний улиралд царцахгүй байхаар телекамер холболтыг шийдвэрлэж ашиглалтын найдвартай ажиллагааг хангасан байдал,
3. Нийтийн тээврийн үйлчилгээнд явдаг тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт хийх
4. Урсгал засварын ажлын явцын мэдээлэл,
5. Нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын явц

Дөрөв. Дүүргүүдэд хийх үзлэг, шалгалтын чиглэл

1. Хог хаягдлын үйлчилгээний байгууллагатай байгуулсан гэрээ, гэрээний үүргийн биелэлтэд дүүрэг, хороо, хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагуудын оролцоо, хяналтыг шалгах,
2. Бодис, давс, элс дайрганы төлөвлөлт, нөөц, цасны жижүүрийн хуваарь, мөрдөлтийг шалгах,
3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, хогийн сав, сандал зэрэг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт, засвар үйлчилгээний гүйцэтгэл, хяналтын байдал,
4. Гудамж, зам талбайн цэвэрлэгээний болон хальтиргаа гулгаа арилгах ажилд ашиглаж буй багаж хэрэгсэл, шинэлэг техник хэрэгслэлийн ашиглалтын байдал,

5. Байгууллага, аж ахуйн нэгжид дүүргээс хариуцуулсан 50м газрын хог хаягдал, цас мөсний цэвэрлэгээ, хальтиргаа гулгаа арилгуулах талаар дүүрэг, Хог хаягдлын үйлчилгээний байгууллагаас авсан арга хэмжээ, гүйцэтгэлийг шалгах,
6. Орон сууц, гэр хороллын ил задгай, үүсмэл албан бус хогийн цэгүүдийн бүртгэл судалгаа, түүнийг шийдвэрлэж буй байдал, авсан арга хэмжээний байдал,
7. Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог тээвэрлэлт, сар бүрийн гүйцэтгэлийн хяналтыг шалгах,
8. Хог тээврийн машин техник, тоног төхөөрөмжийн бүртгэл, ашиглалт, ариутгал, засвар үйлчилгээ, парк шинэчлэлтийг шалгах,
9. Зам талбайн үйлчлэгч, жолооч, ачигч нарын өвлийн нормын хувцасны хангалт, орон тоо, цалингийн хэмжээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар хийгдэж буй ажил, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах,
10. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөний биелэлт /оны эхнээс/-ийг үзэх,
11. Хог хаягдлын чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан сургалт, сурталчилгааны байдлыг шалгах.

Тав. Барилга, орон сууц өмчлөгчдийн холбооны чиглэлээр хийх үзлэг шалгалтын Чиглэл

1. Сууц өмчлөгчдийн холбоо болон иргэд, аж ахуйн нэгж, оршин суугчдаас дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усаа аваагүй байгаа, хүндрэлтэй, доголдолтой байгаа Сууц өмчлөгчдийн холбоонуудыг Монголын Сууц Өмчлөгчдийн Холбооны Дээд зөвлөлтэй хамтарч шалгах,
2. Сууц өмчлөгчдийн холбоо болон иргэд, аж ахуйн нэгжээс хүсэлт гарган шийдвэрлүүлсэн болон шийдвэрлэгдээгүй асуудлыг шалгах /орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн инженерийн шугам сүлжээ, дээврийн ажил/.

Зургаа. Дүнг танилцуулах

Үзлэг, шалгалтын дүнг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулна.